



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/77

Сүхбаатар сум

### Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."г", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15.1, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын 1 дүгээр багийн иргэдийн Нийтийн хурлын дарга, яруу найрагч, зохиолч Т.Доржсүрэн нь элэгний хорт хавдар өвчний улмаас Улаанбаатар хотын Хавдар судлалын үндэсний төвд мэс засалд зайлшгүй орох дүгнэлт, эрүүл мэндийн хүнд байдал, санхүүгийн хүнд нөхцөл, иргэний өргөдлийг үндэслэн үзэж, нэг удаагийн буцалтгүй тусламжийг хавсралтад зааснаар үзүүлсүгэй.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах 500000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ